

**МӨНГӨН ЗЭЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ЗОХИЦУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛ
БОЛОН ХАМТ ӨРГӨН МЭДҮҮЛСЭН ХУУЛИЙН ТӨСЛҮҮДИЙН ХЭЛЭЛЦЭХ
ЭСЭХ ТАЛААРХ ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН ХОРООНЫ
САНАЛ, ДҮГНЭЛТ**

2021 оны 05 дугаар
сарын 13-ны өдөр

Улаанбаатар
хот

Илтгэгч: Улсын Их Хурлын гишүүн Ж.Сүхбаатар

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2021 оны 01 дүгээр сарын 08-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Мөнгөн зээлийн үйл ажиллагааг зохицуулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцэх эсэх асуудлыг Хууль зүйн байнгын хороо 2021 оны 05 дугаар сарын 13-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Барьцаалан зээлдүүлэх үйл ажиллагаа эрхлэгчдэд тавигдах шаардлага болон хяналт тавих байгууллага тодорхойгүй, дур зоргоороо хүү, алданги тогтоож зээлдэгч буюу санхүүгийн хэрэглэгчийн эрхийг ноцтой зөрчдөг, түүнчлэн нэгдсэн бүртгэлгүйн улмаас нийт зээлийн хэмжээ, бичил санхүүгийн зах зээл дэх мөнгөн эргэлт, татвар төлөлтийг бодитой тогтоох боломжгүй байдаг нь далд эдийн засаг бий болох нөхцөлийг бүрдүүлдэг зэрэг хэрэгцээ, шаардлагыг үндэслэн хууль санаачлагч барьцаалан зээлдүүлэх үйл ажиллагааны бүртгэл, хяналт, зохицуулалтын оновчтой тогтолцоог бий болгох, зээлдүүлэгчийн үүрэг, тэдэнд тавих шаардлагыг тодорхой болгох, барьцаалан зээлдүүлэх газрын хүүгийн дээд хэмжээг Санхүүгийн зохицуулах хорооны дэргэд ажиллах Мөнгөн зээлийн үйл ажиллагааны бодлогын зөвлөл тогтоох, мөнгөн зээлийн үйл ажиллагаатай холбоотой өмчлөх эрхийн эсрэг болон мөнгө угаах, татвар төлөхөөс зайлсхийх зэрэг эдийн засгийн гэмт хэргүүдийг бууруулахад чиглэсэн тодорхой зохицуулалтуудыг тусган тус хуулийн төслийг боловсруулсан байна.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаяр хуулийн төсөлтэй хамт Иргэний хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг өргөн мэдүүлсэн бөгөөд Иргэний хууль нь хувийн эрх зүйн харилцааны суурь хууль болохын хувьд тус хуульд өөрчлөлт оруулснаар хувийн эрх зүйн харилцааны бусад хуульд хэрхэн нөлөөлөх, түүнчлэн Санхүүгийн зохицуулах хороонд шинэ чиг үүрэг бий болж байгаатай холбогдуулан орон тоо нэмэгдэх эсэх талаар, Улсын Их Хурлын гишүүн Ж.Сүхбаатар зээлийн хүүгийн дээд хэмжээг тогтооход баримтлах шалгуур үзүүлэлт, одоогийн нөхцөл байдлын талаар, Улсын Их Хурлын гишүүн С.Бямбацогт нэг эзэнтэй хэд хэдэн барьцаалан зээлдүүлэх үйл ажиллагаа нь сүлжээ болсон, хулгайн эд зүйлийг барьцаалах асуудал болон барьцаа хөрөнгийг зах зээлийн үнээс бага үнээр борлуулдаг зэрэг асуудлуудыг хэрхэн зохицуулах, түүнчлэн барьцаалан зээлдүүлэх үйл ажиллагааны хүүгийн дээд хэмжээг хэд байхаар тооцоолж хуулийн төслийг боловсруулсан талаар асуулт асууж, хариулт авсан болно.

Улсын Их Хурлын гишүүн Н.Алтанхуяг мөнгөн зээлийн үйл ажиллагаанд оролцогч болох зээлдэгч, зээлдүүлэгч нарыг ажлын хэсгийн бүрэлдэхүүнд оруулалгүй хуулийн төслийг боловсруулсан нь учир дутагдалтай талаар, Улсын Их Хурлын гишүүн Ж.Сүхбаатар Коронавируст халдвар (Ковид-19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг Улсын Их Хурлын гишүүн Х.Булгантуяатай хамтран боловсруулж, барьцаалан зээлдүүлэх үйл ажиллагааны хүүг гурван хувиас хэтрүүлэхгүй байхаар зохицуулсан нь мөнгөн зээлийн үйл ажиллагааг цэгцлэх эхний

алхам байсан талаар онцолж, төрийн өндөр албан тушаалтан банк бус, санхүүгийн байгууллага, мөнгөн зээлийн аливаа үйл ажиллагаа явуулах, үүнтэй холбоотой тусгай зөвшөөрөл эзэмшихийг хориглох зохицуулалтыг хуулийн төсөлд тусгах шаардлагатай талаар санал хэлсэн болно.

Мөнгөн зээлийн үйл ажиллагааг зохицуулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх буюу 73.3 хувь нь үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Мөнгөн зээлийн үйл ажиллагааг зохицуулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Иргэний хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Иргэний хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай, Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуульд нэмэлт оруулах тухай, Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх талаарх Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА**



С.БЯМБАЦОГТ